

..... оны ..... сарын ..... өдрийн Хоршооны бүх гишүүдийн хурлын .... тоот тогтоолоор батлав.

## ХОРШООНЫ ГИШҮҮДЭД ҮНИЙН ЗӨРҮҮ ОЛГОХ ЖУРАМ

Хоршоо гишүүдийнхээ бий болгож хуримтлуулсан мал мах, ноос ноолуур, арьс шир, түүхий эдийг цуглуулан зах зээлд хамтран болон зуучлан борлуулах үйл явцад үнийн зөрүүг хуваарилах, гишүүдэд нөхөн хуваарилах шаардлага гардаг. Энэ нь нэгдүгээрт, хоршооны хөрөнгө дутагдалтайгаас гишүүддээ эргэн тооцох нөхцөлтэйгээр урьдчилгаа төлж бүтээгдэхүүнийг нь төвлөрүүлсэн, хоёрдугаарт, бүтээгдэхүүнийг төлөвлөж тооцсоноос өндөр ашигтай борлуулсан нөхцөл байдлаас бий болдог.

Энэ үед хоршоонд бий болсон хуримтлал хөрөнгийг гишүүдэд тэгш шудрага хуваарилахад тусгай журамтай байх шаардлагатай.


Үнийн зөрүү тооцох бүтээгдэхүүний нэр төрөл, хоршооны боломжит орлогын хэмжээ буюу ашигт байдлыг хоршооны бүх гишүүдийн болон төлөөлөгчдийн хурлаас тогтооно.

Хоршооны бүх гишүүдийн болон төлөөлөгчдийн хурал нь өөрийн гишүүдээсээ бэлтгэж худалдан борлуулах хөдөө аж ахуйн болон бусад нэгж бүтээгдэхүүнээс хоршооны олбол зохих (хоршоонд ноогдох) ашиг орлогыг нэгбүрчлэн дараах байдлаар тогтооно.

Дү	Бүтээгдэхүүний нэр төрөл	ХН	Нэгж бүтээгдэхүүнээс хоршоонд үлдээх орлого	
			Хувь	Бодит дүн
1	Үхэр	Толгой, эсвэл амьдын жин		
2	Адуу	Толгой, эсвэл амьдын жин		
3	Ямаа	Толгой, эсвэл амьдын жин		
4	Хонь	Толгой, эсвэл амьдын жин		
5	Мах	Килограмм		
6	Тэмээний ноос	Килограмм		
7	Хонины ноос	Килограмм		
8	Ямааны ноолуур	Килограмм		
9	Сарлагийн хөөвөр	Килограмм		
10	Үхрийн шир	Ширхэг		
11	Адууны шир	Ширхэг		
12	Хонины арьс	Ширхэг		
13	Ямааны арьс	Ширхэг		

Үүний зэрэгцээ бүтээгдэхүүний ашгийн түвшинг хоршоо бизнесийн төлөвлөгөө, тооцоондоо өмнө нь тодорхойлсон бол тэр түвшин, хэмжээг баримтална.

Хүснэгтэд нэр заасан бүтээгдэхүүний борлуулалтаас хоршоонд орох цэвэр орлого (борлуулалтаас олсон орлого нь зардлаа нөхөөд, дээр нь хоршооны боломжит хэвийн ашигтай байхаар тодорхойлсноос давуу үнэд хүрсэн байх) нь үнийн зөрүү тооцох үндсэн нөхцөл болно. Үнийн зөрүүг тооцох томьёолол:



Бүтээгдэхүүний үнийн зөрүүг тооцохдоо хоршооны хэвийн ашигт байдлыг хангах үүднээс хооронд нь гүйлгэн тооцох (алдагдалтай буюу ашиг багатай бүтээгдэхүүний боломжит тооцоот ашгийг бусад ашиг сайтай бүтээгдэхүүнийхээр нөхөх) боломжтой.